



ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
САЛБАР ЗӨВЛӨЛҮҮДЭД

**МОНГОЛ УЛС**  
**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ**

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Самбуугийн гудамж 11, Засгийн газрын 11-р байр,  
Утас: 264216, Факс: 264460,  
E-mail: info@csc.gov.mn

2020.09.14 № 01/683  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Тогтоолыг шуурхай хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссоос өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж нийтийг хамарсан арга хэмжээг зохион байгуулахгүй байх чиглэл өгсөнтэй холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 36 дугаар тогтоолоор төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалтуудыг тухайн үед түр хугацаагаар хойшлуулсан байсан.

Коронавирусийн цар тахлын нөхцөл байдал урьдчилан төсөөлөх боломжгүй, үл мэдэгдэх олон сорилтууд байгааг харгалзан төрийн байгууллагын хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг шуурхай хангах үүднээс сул орон тоог нөхөх, хүний нөөцийг бүрдүүлэх тусгай шалгалт, сонгон шалгаруулалтыг зохион байгуулах шаардлага үүсээд байна.

Энэ талаар Төрийн албаны зөвлөлөөс хүргүүлсэн хүсэлтийн дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон Улсын онцгой комиссоос ирүүлсэн санал, шийдвэрийг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 141 дүгээр тогтоолоор төрийн албаны тусгай шалгалт, сонгон шалгаруулалтыг шуурхай зохион байгуулахаар шийдвэрлэлээ.

Тогтоолыг чанд баримтлан, улсын болон орон нутгийн онцгой комисс, эрүүл мэндийн болон мэргэжлийн байгууллагын зөвлөмж, хууль журмын дагуу шалгалтыг зохион байгуулж ажиллах нь зүйтэй.

Тогтоолыг шуурхай хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Төрийн албаны зөвлөлийн Сонгон шалгаруулалтын газартай холбогдон ажиллахыг зөвлөө. /Утас 51-264982/.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ



МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2020 оны 04 сарын 13 өдөр

Дугаар 141

Улаанбаатар хот

Төрийн албаны тусгай шалгалт зохион  
байгуулах талаар авах зарим арга  
хэмжээний тухай

Төрийн албаны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.4, 65 дугаар зүйлийн 65.6, 66 дугаар зүйлийн 66.1.6, 66.1.11, Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.2, “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 3.1.1.а, 4.5 дахь заалт, Улсын онцгой комиссын 2020 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэлээр өгсөн чиглэлийг тус тус үндэслэн төрийн байгууллагын хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангах, төрийн албаны сул орон тоог нөхөх зорилгоор Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Монгол Улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацаанд төрийн албаны тусгай шалгалт, төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах шалгалтыг тусгайлсан, эсхүл хэсэгчилсэн байдлаар үе шаттайгаар хувааж, зайлшгүй шаардлагатай бол ганцаарчилсан байдлаар цахим болон бусад хэлбэрээр, зохион байгуулалтын хувьд хялбаршуулсан горимоор дараах байдлаар шуурхай зохион байгуулсугай:

1.1. Төрийн албаны тусгай шалгалт /тухайн албан тушаалын/-д оролцох иргэнээс хавсралтад заасан баримт бичгийг хүлээн авах, бүртгэх үйл ажиллагааг цахим хэлбэрээр зохион байгуулах;

1.2. Төрийн албаны тусгай шалгалтын тухайн салбар, албан тушаалд хамаарах хууль, эрх зүйн мэдлэг, дүн шинжилгээ хийх, асуудал шийдвэрлэх, монгол хэлний ярианы болон бичгийн чадварын шалгалтыг сорил хэлбэрээр нийт 60-аас илүүгүй минутад, удирдан зохион байгуулах, манлайлах, багаар ажиллах чадварын шалгалтыг ярилцлагын хэлбэрээр 10-аас илүүгүй минутад багтаан тус тус цахим хэлбэрээр зохион байгуулах;

20090379



1.3.Төрийн жинхэнэ албаны нөөцөд бүртгэлтэй иргэдээс тухайн салбар, албан тушаалд хамаарах хууль, эрх зүйн мэдлэг, монгол хэлний ярианы болон бичгийн чадварын тусгай шалгалтыг сорил хэлбэрээр нийт 30-аас илүүгүй минутад багтаан цахим хэлбэрээр авч төрийн захиргааны туслах түшмэлийн сул орон тоог нөхөх;

1.4.Төрийн албаны сул орон тоо нөхөх зарыг шалгалтын бүртгэл эхлэхээс ажлын гурваас доошгүй өдрийн өмнө Зөвлөлийн болон төрийн байгууллагын цахим хуудсаар зарлах;

1.5.Төрийн албаны тусгай шалгалтын бүртгэлийг ажлын нэг өдрийн хугацаанд хийх;

1.6.Тусгай шалгалтын комисс шалгалтын тайланг шалгалт дууссанаас хойш Төрийн албаны зөвлөл, Салбар зөвлөлд ажлын нэг өдөрт багтаан хүргүүлэх.

2.Төрийн албаны тусгай шалгалтыг цахим хэлбэрээр зохион байгуулахаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба, Салбар зөвлөлд тус тус даалгасугай:

2.1.Төрийн албаны тухай хууль /Шинэчилсэн найруулга/, холбогдох журмаар тогтоосон чадахуйн зарчим, шатлан дэвших журмыг баримтлан төрийн албаны тусгай шалгалтыг цахим хэлбэрээр явуулах бэлтгэл ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, тусгай шалгалт зохион байгуулах, хяналт тавих, үр дүнг тухай бүр танилцуулж ажиллах;

2.2.Улсын онцгой комиссын шийдвэр, Эрүүл мэндийн яамны зөвлөмж чиглэлийг мөрдөх, коронавируст (COVID-19) халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг тухай бүр авах;

2.3.Тусгай шалгалтыг цахим хэлбэрээр зохион байгуулахад техник тоног төхөөрөмж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, үүсч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх шаардлагаар төрийн болон эрх бүхий бусад байгууллагатай хамтарч ажиллах;

2.4.Төрийн албаны тусгай шалгалт авахтай холбоотой энэхүү тогтоолоор журамлаагүй бусад харилцаанд Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”, 25 дугаар тогтоолоор баталсан “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-ыг тус тус мөрдөж ажиллах.

3.Төрийн албаны тусгай шалгалтыг цахим хэлбэрээр энэхүү тогтоолын дагуу зохион байгуулах ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, хяналт тавих, Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба, Салбар зөвлөлд мэргэжил, арга зүйн зөвлөгөө чиглэл өгч, үр дүнг хариуцан ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Д.Баатарсайханд даалгасугай.

4.Төрийн албаны тусгай шалгалтыг цахим хэлбэрээр зохион байгуулахаар шийдвэрлэсэнтэй холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 3-ны өдрийн “Төрийн албаны шалгалтыг хойшлуулах тухай” 36 дугаар тогтоолын 1 дэх заалтын “тусгай” гэснийг хассугай.

5.Энэхүү тогтоолыг Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөл, иргэд, олон нийтэд хүргэх, танилцуулах, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, дэмжлэг үзүүлж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын алба /Л.Санжрагчаа/-д даалгасугай.

6.Энэхүү тогтоолыг гамшгийн нөхцөл байдал арилсан тухай эрх бүхий байгууллагаас албан ёсоор нийтэд зарлан мэдээлэх хүртэл хугацаанд дагаж мөрдсүгэй.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ